



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 8/1187

Баруун-Урт сум

Дэд зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 222, 2017 оны 263 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах, тайлагнах үүрэг бүхий аймгийн Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Дэд зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох ажил, арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Дэд зөвлөл /Д.Шижирбаатар/-д даалгасугай.

3. Нутаг дэвсгэрт нь ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул олборлолтын үйл ажиллагаа явуулдаг сумдад Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.3, 11.4, 11.5 дах заалтуудыг хэрэгжүүлэх дэд зөвлөлийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж холбогдох мэдээллийг аймгийн дэд зөвлөлд тайлагнан хэрэгжилтийг хангуулж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Дэд зөвлөл байгуулах тухай" Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/125 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

4 0000361

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 0178 дүгээр захирамжийн хавсралт



Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх аймгийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүн

Дэд зөвлөлийн дарга

- Аймгийн Засаг даргын дэд бүтэц хариуцсан орлогч

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн

- Байгаль, орчин аялал жуулчлалын газрын газрын газрын хэвлий, тусгай хамгаалалт хариуцсан ахлах мэргэжилтэн

- "Их бага баян шарга" ТББ-ын тэргүүн

- Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн Сүхбаатар аймгийн салбар зөвлөлийн төлөөлөл-1

- МҮХАҮТ-ийн Сүхбаатар аймаг дахь салбар танхимын дарга

- "Уул уурхайгүй Эрдэнэцагаан" ТББ-ын төлөөлөл-1

- Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Сүхбаатар аймаг дахь салбарын төлөөлөл-1

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөөлөл болж "Цайрт минерал" ХХК, "Эм Эл Цахиурт-Овоо" ХХК, "Эрдэнийн босго", "Хунт өгөөж" ХХК-ийн захирлууд

- Тус аймагт газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн төлөөлөл болж "Макс ойл" ХХК-ийн гүйцэтгэх захирал

Нарийн бичгийн дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн уул уурхай, зам тээврийн бодлого хариуцсан мэргэжилтэн

-----oOo-----